

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. Хөтөлбөрийн нэр/ индекс

Урлагийн боловсрол 011418

1.2. Сургалт явуулах хэлбэр

/өдөр, эчнээ/, /танхим, онлайн холимог/

1.3. Хөтөлбөрийг хариуцах сургууль, салбарын нэр, харилцах хаяг

МУБИС-ийн Багшийн сургууль, ДУТС

Тэнхимийн эрхлэгч: Ч.Отгонбаяр, Б.Галбадрах

И-мэйл хаяг: otgonbayar.ch@msue.edu.mn, gal.badrakh@msue.edu.mn

Хаяг: МУБИС-ийн хичээлийн 5 дугаар байрны 306 тоот

Утас: 89026171, 99122025.

Хаяг: Улаанбаатар, СБД, 8 дугаар хороо, Бага тойруу – 14, МУБИС-ийн V байр 306 тоот

1.4 Хөтөлбөрийг боловсруулсан багийн гишүүдийн мэдээлэл

Хүснэгт 1.1. Хөтөлбөрийн багийн гишүүдийн мэдээлэл

№	Багийн гишүүд	Зэрэг, цол	Төгссөн сургууль	Мэргэжил
1	Ч.Отгонбаяр	Доктор (Ph.D)	Хөгжим бүжгийн коллеж, БНХАУ-ын Шанхайн хөгжмийн косерватори, СУИС, Бээжингийн багшийн их сургууль	Хөгжимчин, хөгжийн сургуулийн багш, урлаг судлал, хөгжим судлал
2	Ц.Эрдэнэтуяа	Доктор (Ph.D)	Сурган хүмүүжүүлэх ухааны коллеж, ОХУ-ын Москвагийн улсын багшийн их сургууль	Хөгжмийн багш, найрал дууны удирдаач, судлаач багш
3	Г.Заяабат	Доктор (Ph.D)	СГДС, СУИС, МУБИС	Хөгжмийн багш, соёлын ажилтан, арга зүйч, боловсрол судлал
4	А.Ариунболд	Доктор (Ph.D)	УБИС	Дүрслэх урлаг, технологийн багш
5	Ц.Эрдэнэцог	Доктор (Sc.D)	ОХУ, Санкт Петербург Репиний нэрэмжит Уран зургийн академи, Москвагийн УБИС.	Зураач, багш
6	Г.Одпүрэв	Доктор (Art)	УБИС, Польш Вроцлавын Урлагийн Академи	Дүрслэх урлаг, дизайны багш, урлаг судлаач
7	Т.Сэлэнгэ	Доктор (Ph.D)	УБИС, МУИС	Урлаг судлаач багш

1.5 Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх улирал: 2020 оны намрын улирал

1.6 Хөтөлбөрийг албан ёсоор баталгаажуулсан тухай мэдээлэл

Энэхүү хөтөлбөрийг анх БШУ-ны сайдын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 дугаар тушаал, МУБИС-ийн захирлын 2020 оны 01-р сарын 18-ны өдрийн А/224 дүгээр тушаалаар Е01140402 индекстэй батлан хэрэгжүүлж байсан бол БШУ-ны сайдын 2023 оны 09-р сарын 09-ний өдрийн А/343 дугаар тушаал, МУБИС-ийн захирлын тушаалаар 2022 онд шинэчлэн баталсан. Мөн тухай бүр МУБИС-ийн хөтөлбөрийн дэд, салбар, ерөнхий хороодоор тус тус хэлэлцүүлэн сайжруулсан байна.

1.7 Сургалт явуулж ирсэн түүх, туршлага

МУБИС нь бүрэлдэхүүний 7 сургууль, салбар 2 сургууль, 1 цэцэрлэг, 1 Ерөнхий боловсролын сургуультайгаар үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын магадлан итгэмжлэлийг 1999, 2004, 2018 онуудад хийлгэсэн. МУБИС нь 2014 оноос эхлэн сургалтын кредит системд шилжсэн. Бакалаврын түвшинд 36 хөтөлбөрийн 41 мэргэжлээр 8.035, магистрын түвшинд 45 мэргэжлээр 2.217, докторын түвшинд 17 мэргэжлээр 1.007 суралцагчтай бөгөөд үүний 1.548 суралцагч нь гадаад оюутан байна. Багшийн сургууль бүрэлдэхүүний сургууль бөгөөд “Багш, бага ангийн боловсрол”, “Багш, урлагийн боловсрол” гэсэн бакалаврын, болоод ахисан түвшний хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Багшийн сургууль нь Монгол Улсад мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж эхэлсэн анхны ууган сургуулийн нэг юм. 1922 онд анх “Багш нарын түр курс” нэртэйгээр 2 багш, 15 сурагчтайгаар нээн хичээллүүлж эхэлж байсан. МУБИС-ийн багшийн сургууль нь 4 тэнхим, 38 багш, 1417 оюутан, захиргаа, нийтлэг үйлчилгээний 34 ажилтан, 2 хичээлийн байр, 5 лаборатори, 40 гаруй анги танхимд үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуульд 10 –аас дээш жил ажиллаж байгаа багш нар 92 хувьтай байна.

Багш нар Япон, Хятад, Солонгос, ОХУ –д магистр, докторын зэрэг хамгаалсан. Багшийн сургуулийн хувьд Японы Tokyo Gakugei University (2007), Nagoya University, Graduate School of Education and Human Development, School of Education (2013), Финляндын University of Lapland /Finland/ (2015), АНУ-ийн Columbia college (2011) зэрэг сургуулиудтай хамтран багш солилцох, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, эрдэм шинжилгээний хурал болон сургалт зохион байгуулах, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар судалгаа хийх, хөтөлбөрт судалгаа шинжилгээ хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Багшийн сургууль нь “Багш, бага ангийн боловсрол”, “Багш урлагийн боловсрол” гэсэн хоёр сургалтын хөтөлбөрөөр ЕБС-ийн бага ангийн болон дуу хөгжмийн багш бэлтгэдэг.

Японы Нагояа их сургуультай хамтарсан Хүүхдийн хөгжлийг дэмжих төв, Бага боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн төв, практик сургалтын “Тусгал инкубатор”, Эко боловсрол олгох “Ногоон замнал” зэрэг багш, оюутны бие даалтын төвүүд ажилладаг. 1998 оноос магистрын сургалтаа эхлүүлж, монгол, өвөр монгол оюутныг ахисан түвшний сургалтдаа хамруулж ирсэн. Сургалт цахим болон танхимын гэсэн хоёр хэлбэрээр хэрэгжиж байна.

1.8 Хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл, эрэлт хэрэгцээ

Өнөөдөр дэлхийн боловсролын чанарын шинэчлэл суралцагчийг тодорхойгүй ирээдүйд бэлтгэх, төвөгтэй асуудлыг таньж мэдэх, шийдэх, дасан зохицох чадвар эзэмшүүлэх, энтрепренёр сэтгэлгээг төлөвшүүлэх, инноватор, бизнес удирдагчдыг

дэмжин хөгжүүлэхэд бэлтгэхэд чиглэж байна. Үүнээс үндэслэн дасан зохицох, бие даан ажиллах, харилцааны чадварыг хөгжүүлэхэд бага боловсролын зорилгыг чиглүүлж, эдгээр чадварыг хөгжүүлдэг багшийн хэрэгцээ үүссэнээс хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго, хичээлийн агуулга, арга зүй шинээр томъёологдож, дахин бага ангийн багш бэлтгэх асуудлыг шинээр дизайнчлах хэрэгцээ гарч шинэчилсэн загвартаа 3,5+1,5 гэсэн загвар оруулж, 1,5 жилээр магистр бэлтгэнэ. Хөтөлбөрийн үзэл баримтлалын шинэчлэгдсэн тулгуур ойлголтууд :

- Шинэ эриний суралцагчийн сурах хэв маягт тулгуурлах
- Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог хөгжүүлэх(Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр)
- Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, 2. боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, 3. Улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. (Алсын хараа 2050, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого)
- Боловсролын өөрчлөлтийн шаардлага, (Jarvis P., 1989) багшлахуйгаас суралцахуйд, амьдралын турш суралцах, МТХ мэдлэг түгээх хэрэгсэл болгох, салбар хоорондын мэдлэг
- Багшийн үүрэг сурах соёлыг бий болгох, дасгалжуулагч байх, харилцан яриа, маргаан, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлж, нийгмийн харилцааг дэмжиж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байх ёстой (Ариунболд.Ж, 2022.,СХБОАЗ)
- Боловсролын салбарт баримталж буй үзэл баримтлал, парадигмын нөөц шавхагдсаныг ухаарч системийн сэтгэлгээний үндсэн дээр бүх талын оролцоотой боловсролын систем, сургалтын байгууллагуудыг дахин дизайн хийх (Бадарч.Д, Системийн сэтгэлгээ)
- Хүмүүнлэгийн үнэт зүйлийг бүх талаар дэмжих
- Амьдралын турш ур чадвар, чадамж эзэмшүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тогтвортой ирээдүйд бэлтгэх
- Цахим ба хүмүүний харилцааны ирээдүйг тэгш хүртээмжтэй, ёс зүйтэй болгох (Их сургуулиудыг өөрчлөх 7 чиглэл, 1999, 2030 он хүртэлх дээд боловсролын талаарх цогц бодлого)

Багш мэргэжлийн тодорхойлолтод багш мэргэжлийн чадамж, заадаг хичээлийн чадамжийг хүрээ болгон авч үзэж байсан бол хувьсан буй боловсролын шинэчлэл багш мэргэжлийн чадамжийн хүрээг өдөр бүр сайн багш байх, юу зааж байгаага мэддэг байх, суралцагчаа дэмжих чиглүүлэх, нийгэмд байр сууриа эзлэх гэсэн 4 чадамжийн хүрээнд хувааснаас үндэслэн Багшийн сургуулийн багш бэлтгэх чадамжийн хүрээг 2014 оноос хойш хувь хүний чадамж, багш мэргэжлийн чадамж, мэргэшиж буй мэргэжлийн чадамж гэсэн 3 хүрээгээр тодорхойлж, заадаг хичээлийн, судалгааны ажил эрхлэх, хөтөлбөр, агуулга хөгжүүлэх, сэтгэл хөдлөлийн, нийгэмшихүй соёлын, насан туршдаа суралцахуйн, харилцаа холбоо тогтоох, мэдээлэл харилцааны, байгаль орчны, дижитал хэл, сэтгэлгээний чадамжууд гэж ангилж, багш бэлтгэх зорилгоо тодорхойлж багш мэргэжлийн түвшингээ бакалавр, ахисан түвшин гэж ялган ахисан түвшний сургалтын хөтөлбөрөө мэргэжлийн болоод судлаач багш бэлтгэхэд зохилгод нийцүүлэн 2 өөрөөр хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

2.1. Сургуулийн эрхэм зорилго, зорилт:

МУБИС-ийн эрхэм зорилго, зорилтууд

Боловсролын салбарыг хүүхэд бүрийг хөгжүүлэх чадвартай бүтээлч багш, мэргэжлийн хүн хүчний нөөцөөр хангах

Багшийн сургуулийн эрхэм зорилго

Нийгмийн багш хувь хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мэргэшсэн багш, боловсролын болон бусад салбарын мэргэжилтэн бэлтгэх

Багшийн сургуулийн зорилт:

Ард иргэдэд боловсрол эзэмших, тасралтгүй хөгжих, дахин мэргэшихэд шаардлагатай боловсролын үйлчилгээг нээлттэй, тэгш хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хүргэнэ.

2.2. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ “Урлагийн боловсрол” магистрын хөтөлбөрийн зорилго

Урлагийн боловсролын онол, үзэл баримтлалын талаар мэдлэгтэй, хөгжмийн чиглэлээр судалгаа хийж, шинжлэх ухаанчаар хандаж, судалгааны үндэстэй шийдвэр гаргах чадвартай багшлахуйн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, боловсролын байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилт

1. Урлагийн боловсролын нэр томьёо, ухагдахуун, онол, үзэл баримтлалын мөн чанарыг ойлгож, тэдгээрийн хөгжлийг уламжлал болон шинэчлэлийн үүднээс харьцуулан судалж, боловсролын практикт хэрэглэх;
2. Хөгжмийн боловсролын бодлого, эрх зүйн баримт бичиг, үндэсний хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, боловсролын үйлчилгээг хүргэхэд шаардагдах нөөц, үйл явцыг тодорхойлох, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх;
3. Судлан шинжлэх арга зүй, арга, аргачлал боловсруулан судалгаа, шинжилгээний ажилдаа хэрэглэх;
4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, тайлан, бүтээлд задлан шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний ажлын арга барил эзэмшиж, өөрийн бүтээлийг боловсруулах, хэвлэх;
5. Судалгааны мэдээлэл, эх сурвалж цуглуулах, нэгтгэх, үр дүн боловсруулахад МХТ болон гадаад хэл хэрэглэх;
6. Суралцагч, багшийн хөгжил, хувийн онцлог, өвөрмөц байдал, төлөвшлийг шинжлэх ухааны үндэстэй судлах, тэдний ахиц амжилт, хөгжлийг үнэлж, дэмжих, бусдад хүндэтгэлтэй харьцах;
7. Боловсролын судалгааны ажилд ёс зүйтэй хандах, бусдын нэр хүндийг хүндэтгэх, хамтран ажиллах;
8. Өөрийн хөгжих хэрэгцээгээ ухамсарлах, насан туршдаа суралцах хандлага, чадамжтай болгон хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилт оршиж байна.

2.3. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн

1. Хувь хүний мэдлэг, чадвар, хандлага

- 1.1. Салбар шинжлэх ухааны онол, арга зүйн хөгжлийн шинэ чиг хандлагыг нийгмийн хөгжилтэй холбон тайлбарлах
- 1.2. Мэргэжлийн болон боловсролын судалгааны ажлын арга зүй эзэмшсэн, үр дүнг боловсруулахдаа орчин үеийн технологи сонгон ашигладаг, судалгааны

- бүтээлүүдээс эш татаж, зүй зохистой ашиглан эрдэм шинжилгээний оновчтой дүгнэлт хийх
- 1.3. Судалгааны ажлын үр дүнг эх хэлээрээ шинжлэх ухааны үндэстэй бичдэг, найруулдаг, хэлэлцүүлэх
 - 1.4. Англи болон түгээмэл гадаад хэлээр мэргэжлийн мэдээлэл ашиглах, бичих, хэлэлцүүлэх, өөртөө итгэлтэйгээр, бусдад ойлгомжтой илтгэх
 - 1.5. Судлаачид, эцэг эх, сургуулийн удирдлага, хамт олон, багш нар, судалгаанд оролцогчид, суралцагчидтай бие даан болон багаар хамтран ажиллах
 - 1.6. Судалгаанд суурилан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр асуудалд ханддаг.
 - 1.7. Оюуны өмчийг дээдлэн судлаачийн ёс зүйг баримтлах
 - 1.8. Мэргэжлийн онол болон судалгааны арга барилд тасралтгүй суралцаж, нээлттэй хөгжлийг хамтдаа эрэлхийлэх

2. Урлагийн боловсролын магистрын мэдлэг, чадвар, хандлага

- 2.1 Урлагийн боловсролын шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, судлагдахууныг ойлгох, холбоо хамаарлыг нь тодорхойлох, судалгааны ажлын онолын үндэс болгон ашиглах
- 2.2 Урлаг судлал болон урлагийн боловсролын судалгааны ажлын арга зүйг эзэмшсэн, судалгааны загварчлалыг оновчтой боловсруулдаг, судалгааг шинжлэх ухааны уулзварт хийж гүйцэтгэдэг, орчин үеийн дэвшилтэт технологи ашигладаг, судалгааны ажлын үр дүнг хэрэглээнд нэвтрүүлж, судалгааны болон судлаачийн академик ёс зүйг баримтлах
- 2.3 Академик бичвэрт суралцах, эх хэлний найруулга зүйг эзэмших, судалгааны программуудыг ашиглах, зөв цэгцтэй илтгэж сурах
- 2.4 Англи болон түгээмэл гадаад хэлнээс онол, арга зүйн материал ашиглах, боловсруулах, судалгааны үр дүнг нээлттэй хэлэлцүүлэх, эргэлтэнд оруулах, түгээн дэлгэрүүлэх
- 2.5. Урлагийн боловсролын үзэл баримтлалын дагуу тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх ба нийгмийн хөгжилтэй холбон тайлбарлах
- 2.6. Урлагийн боловсролоор дамжуулан гоо зүйн боловсролыг хөгжүүлэх, зөөлөн ур чадварыг эзэмшүүлэх, нийгэм соёлын хөгжлийн зүй тогтол, ялгааг танин мэдэх, цогц хөгжлийг дэмжих